



МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ОЛИМП, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН  
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/05

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.5-д тус тус үндэслэн Тушаах нь:

1.Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдон биеийн тамир, спортын салбарт мөрдөгдөж байгаа захиргааны хэм хэмжээний акт буюу нийтээр дагаж мөрдүүлж буй журмуудыг салбарын санд шинэчлэн бүртгүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, журмын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Журам бүртгүүлэх үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны дарга /О. Баттулга/-д даалгасугай.

Монгол Улсын сайд, Олимп,  
нийтийн биеийн тамир, спортын  
Үндэсний хорооны дарга



Б.БАТ-ЭРДЭНЭ

000509

Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний  
хорооны даргын 2023 оны 05 дугаар сарын 17-ний  
өдрийн 1/05 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРТ МӨРДӨГДӨЖ  
БАЙГАА ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫГ ШИНЭЧЛЭН БҮРТГҮҮЛЭХ  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

**АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ:**

Биеийн тамир, спортын улсын хорооны  
даргын үүрэг гүйцэтгэгч

О.Баттулга

**АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮД:**

Хуулийн асуудал хариуцсан ахлах  
мэргэжилтэн  
Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн  
Дарга  
Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн  
хэлтсийн дарга  
Үндэсний шигшээ багийн бодлого  
хэрэгжилтийн хэлтсийн дарга

Ц.Батцайз

Б.Нямсүрэн

О.Баасан


Э.Билэгт

**АЖЛЫН ХЭСГИЙН НАРИЙН БИЧИГ:**

Биеийн тамир, спортын бодлого, төлөвлөлт  
хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

С.Мөнх-Эрдэнэ

Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын 2023 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 1/05 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРТ МӨРДӨГДӨЖ  
БАЙГАА ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТ  
БУЮУ ЖУРМЫН ЖАГСААЛТ**

Д/д	Тушаалын		Баталсан албан	Тушаалын утга	Бүртгэгдсэн	
	дугаар	огноо			огноо	дугаар
1	24/19	2002.01.24	Эрүүл мэндийн сайд, Санхүү эдийн засгийн сайд	Журам батлах тухай "Үндэсний шигшээ баг бүрдүүлж, тэмцээнд оролцуулах журам"-ыг хоёрдугаар хавсралтаар /Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 53/45 дугаар тушаалаар нэгдүгээр хавсралтыг хүчингүй болгосон УБД 3036/	2007.11.19	2808
2	53/45	2009.02.18	Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд	Журам шинэчлэн батлах тухай /Спортын их наадам, Улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах, санхүүжүүлэх журам, Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадам зохион байгуулах, санхүүжүүлэх журам/	2009.06.11	3036
3	A/250/A/ 379/437	2015.11.03	Хууль зүйн сайд, Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлалын сайд, Эрүүл мэнд, спортын сайд,	Иргэний болон харуул хамгаалалтын ангилалд хамаарах галт зэвсэг, сумны нэр, төрлийн жагсаалт батлах тухай	2015.11.05	3571
4	433/ A/248	2015.10.30	Эрүүл мэнд, спортын сайд, Хууль зүйн сайд	Буудлага үйлдэх байгууламж /ТИР/-Д тавигдах шаардлага	2015.11.16	3580
5	468, A/268	2015.12.02	Эрүүл мэнд, спортын сайд, Хууль зүйн сайд	Журам батлах тухай /спорт сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх, эрх бүхий этгээдийн галт зэвсэг эзэмших, хадгалах/	2015.12.03	3586
6	A/167	2018.04.03	Боловсрол шинжлэх ухааны сайд	Журам батлах тухай /Үндэсний шигшээ баг бүрдүүлэх, спортын төрлийг сонгох/	2018.05.01	3891
7	A/839	2018.12.28	Боловсрол шинжлэх ухаан, спортын сайд	Журам батлах тухай /спортын сургалт, дасгалжуулалтыг удирдах, тэмцээнд оролцуулах/	2019.01.14	4150
8	A/178, A/144	2019.03.29	Боловсрол шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайд	Журам батлах тухай /спортын клубыг магадлан итгэмжлэх/	2019.05.01	4362